


2019 ОНЫ I УЛИРАЛЫН ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТАЙЛАН

1. Үнэт цаасны арилжаа

2019 оны I улиралд нийт 59 удаагийн арилжаагаар хувьцааны хоёрдогч зах зээлд 101 компанийн 67.4 сая ширхэг хувьцааг 29.1 тэрбум төгрөгөөр, анхдагч зах зээлийн арилжаагаар 2 компанийн 120 сая ширхэг хувьцааг 15.2 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 49.6 мянган ширхэг үнэт цаасыг 4.8 тэрбум төгрөгөөр тус тус арилжаж, нийт 49.2 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий арилжаа хийсэн байна.

Нийт арилжааны үнийн дүнгийн 31% буюу 15.2 тэрбум төгрөгийг хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа, 59.1% буюу 29.1 тэрбум төгрөгийг хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа, 9.85% буюу 4.8 тэрбум төгрөгийг ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаа тус тус эзэлж байна.



Нийт арилжааны хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад:

2018 оны I улирал		Тоо ширхэг	Үнийн дүн /төг/	2019 оны I улирал		Тоо ширхэг	Үнийн дүн /төг/
Хувьцаа	Анхдагч	200,000,000	5,000,000,000	Хувьцаа	Анхдагч	120,000,000	15,285,000,000
	Хоёрдогч	73,479,581	12,629,089,746		Хоёрдогч	67,443,791	29,137,238,580
ЗГ-ын үнэт цаас	Хоёрдогч	244,863	24,342,926,350	ЗГ-ын үнэт цаас	Хоёрдогч	49,592	4,854,184,170
Компанийн бонд	Хоёрдогч	265	26,500,000	Компанийн бонд	Хоёрдогч	0	0
Нийт		273,724,709	41,998,516,095	Нийт		187,493,383	49,276,422,750

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 835.2 сая төгрөгийн гүйлгээ хийж, 3.1 сая ширхэг үнэт цаас арилжсан байна.

1.1 Хувьцааны анхдагч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд нийтэд санал болгон гаргасан “Түмэн шувуут” ХК-ийн 50 сая ширхэг хувьцааг 10 тэрбум төгрөгөөр, “Ард даатгал” ХК-ийн 70 сая ширхэг хувьцааг 5.28 тэрбум төгрөгөөр тус тус анхдагч зах зээлд амжилттай арилжлаа. Анхдагч зах зээлд нийт 15.28 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 31 хувийг эзэлж байна.

1.2 Хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд нийт 59 удаагийн арилжаагаар 101 компанийн 67.4 сая ширхэг хувьцааг 29.1 тэрбум төгрөгөөр арилжсан байна. Нийт 101 компанийн үнэт цаас арилжигдсанаас өмнөх оны мөн үетэй харьцуулахад 30 компанийн үнэт цаасны ханш өсч, 6 компанийн үнэт цаасны ханш буурч, 3 компанийн үнэт цаасны ханш тогтмол байлаа.

1.3 Хувьцааны багцын арилжаа

Тайлант хугацаанд багцын арилжаагаар “Хот деволопмент” ХК-ийн 29.7 мянган ширхэг хувьцааг 1.4 сая төгрөгөөр, “Хөвсгөл алтандуулга” ХК-ийн 1.29 сая ширхэг хувьцааг 1.26 тэрбум төгрөгөөр, “АПУ” ХК-ийн 25.6 сая ширхэг хувьцааг 18.4 тэрбум төгрөгөөр тус тус арилжсан байна. Нийт 19.7 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 26.97 сая ширхэг хувьцааг багцын арилжаагаар арилжсан нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны үнийн дүнгийн 67.7 хувийг эзэлж байна.

Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаас

ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ	ЭРЭМБЭ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
АПУ	29,295,217	1	АПУ	20,730,168,679
ЛЭНДМН ББСБ ХК	20,227,305	2	ЛЭНДМН ББСБ ХК	1,421,489,966
АРД КРЕДИТ ББСБ ХК	6,208,319	3	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	1,399,981,322
ГОВЬ	3,010,836	4	ГОВЬ	997,288,719
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	1,443,523	5	АРД ДААТГАЛ ХК	808,985,515
ТҮМЭН ШУВУУТ	1,178,141	6	МАНДАЛ ДААТГАЛ	598,853,402
АРД ДААТГАЛ ХК	1,156,724	7	АРД КРЕДИТ ББСБ ХК	549,229,432
АЙТҮҮЛС	696,910	8	ТАВАН ТОЛГОЙ	537,722,365
НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	694,012	9	ШАРЫН ГОЛ	500,130,395
МОНГОЛ БАЗАЛТ ХК	633,264	10	ТҮМЭН ШУВУУТ	227,008,808
СҮҮ	532,403	11	МОНГОЛ БАЗАЛТ ХК	163,643,234
МОНИНЖБАР	511,888	12	ЖИНСТ-УВС	121,044,290
РЕМИКОН	365,384	13	ЭРДЭНЭ РЕСУРС ХК	115,436,343
ШАРЫН ГОЛ	310,099	14	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	113,573,777
УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	236,765	15	СҮҮ	109,675,898
ЭРДЭНЭ РЕСУРС ХК	214,681	16	ТАЛХ ЧИХЭР	104,990,540
МОНГОЛ ШУУДАН ХК	178,829	17	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	104,130,650
МАНДАЛ ДААТГАЛ	116,567	18	МОНГОЛ ШУУДАН ХК	99,541,724
ТАВАН ТОЛГОЙ	76,831	19	АЙТҮҮЛС	68,721,984
ЖИНСТ-УВС	68,454	20	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	54,972,700
НИИТ	67,156,152		НИИТ	28,826,589,743
НИИТЭД ЭЗЛЭХ ХУВЬ	99.57%		НИИТЭД ЭЗЛЭХ ХУВЬ	98.93%

Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан ширхэгийн 99.57 хувь, үнийн дүнгийн 98.93 хувийг тус тус эзэлж байна.

Ханшийн өсөлттэй 20 компани

Симбол	Үнэт цаас	2018.03.30	2019.03.29	Ханшийн өөрчлөлт /төг/	Ханшийн өөрчлөлт /%/
BOE	ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ	460.00	1,000.00	540.00	117.39
DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	517.51	1,051.00	533.49	103.09
HZB	ГАН ХЭРЛЭН	2,903.00	5,320.00	2,417.00	83.26
HJL	ОРХОН ХӨГЖИЛ	188.00	328.80	140.80	74.89
HRD	ХҮРД	1,610.00	2,814.00	1,204.00	74.78
VIK	БАЯН-АЛДАР	580.00	1,001.00	421.00	72.59
BTG	БАЯНТЭЭГ	14,600.00	24,000.00	9,400.00	64.38
BNB	БАЯЛАГ НАЛАЙХ	205.00	333.00	128.00	62.44
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	46.26	69.32	23.06	49.85
HSG	ХЭСӨГ ТРЕЙД	1,430.00	1,901.00	471.00	32.94
HSR	ХАСУ-МАНДАЛ	4,400.00	5,690.00	1,290.00	29.32
GOV	ГОВЬ	234.80	293.60	58.80	25.04
OLL	ОЛЛОО	68.00	80.00	12.00	17.65
HHN	ХАРХОРИН	1,500.00	1,750.00	250.00	16.67
JIV	ЖИНСТ-УВС	1,709.00	1,978.00	269.00	15.74
BTL	БАЯНТАЛБАЙ	65.00	74.75	9.75	15.00
MDZ	МОНГОЛ ДИЗЕЛЬ	357.07	410.63	53.56	15.00
ERS	МОНГОЛ АЛТ	7,995.00	9,000.00	1,005.00	12.57
SUL	ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ	113,600.00	125,200.00	11,600.00	10.21
JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	145.00	155.00	10.00	6.90

Ханшийн бууралттай 20 компани

Симбол	Үнэт цаас	2018.03.30	2019.03.29	Ханшийн өөрчлөлт /төг/	Ханшийн өөрчлөлт /%/
EAZ	ЭРДЭНЭТ АВТО ЗАМ	1,100.00	370.00	-730.00	-66.36
CHR	УВС ЧАЦАРГАНА	1,100.00	448.31	-651.69	-59.24
NIE	НОЁТ ХАЙРХАН	1,150.00	478.00	-672.00	-58.43
UYN	МОНГОЛ САВХИ	1,076.00	502.00	-574.00	-53.35
HSX	ХИШИГ УУЛ	1,000.00	500.00	-500.00	-50.00
BAN	БАГАНУУР	2,140.00	1,105.00	-1,035.00	-48.36
ORD	ОРХОНДАЛАЙ	3,100.00	1,621.00	-1,479.00	-47.71
NUR	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	10,000.00	5,300.00	-4,700.00	-47.00
DZG	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	172.00	92.00	-80.00	-46.51
DRU	ДӨРВӨН-УУЛ	1,950.00	1,050.00	-900.00	-46.15
ALI	СТАНДАРТ НООС	500.00	293.25	-206.75	-41.35
GTJ	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	1,486.00	900.00	-586.00	-39.43
TTL	ТАВАН ТОЛГОЙ	11,580.00	7,225.00	-4,355.00	-37.61
MBW	МОНГОЛ БАЗАЛТ ХК	380.00	247.00	-133.00	-35.00
MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	301.00	200.00	-101.00	-33.55
HGN	ХӨХ ГАН	90.00	60.00	-30.00	-33.33
DAH	ДАРХАН ХӨВӨН	15,000.00	10,000.00	-5,000.00	-33.33
TEX	ТЕХНИК ИМПОРТ	20,700.00	13,830.00	-6,870.00	-33.19
MIB	МОНИНЖБАР	149.00	100.00	-49.00	-32.89
BDS	БИ ДИ СЕК	1,200.00	820.00	-380.00	-31.67

2. Засгийн газрын үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй байна. ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлд 49.6 мянган ширхэг үнэт цаасыг 4.8 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

3. Зах зээлийн үнэлгээ

Нийт зах зээлийн үнэлгээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 134.6 тэрбум төгрөгөөр буюу 5 хувиар буурч, 2 их наяд 452.7 тэрбум төгрөг болсон байна.

Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компани


д/д	Компанийн нэрс	Зах зээлийн үнэлгээ
1	АПУ	672,158,352,505.86
2	ТАВАН ТОЛГОЙ	380,506,070,000.00
3	МИК ХОЛДИНГ	243,748,696,400.00
4	ГОВЬ	229,041,030,000.00
5	СҮҮ	73,017,440,000.00
6	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	60,111,525,800.00
7	МОНГОЛ ШУУДАН ХК	58,826,660,487.73
8	ЛЭНДМН ББСБ ХК	55,456,000,000.00
9	УБ-БҮК	44,594,602,500.00
10	ТҮМЭН ШУВУУТ	33,974,000,000.00
11	МАНДАЛ ДААТГАЛ	31,964,241,920.00
12	ГУТАЛ	25,979,878,200.00
13	ШИВЭЭ ОВОО	25,858,607,627.00
14	БАГАНУУР	23,176,667,800.00
15	АРД КРЕДИТ ББСБ ХК	22,817,200,000.00
16	ТЕХНИК ИМПОРТ	20,008,621,650.00
17	БАЯН-АЛДАР	19,942,601,679.00
18	ШАРЫН ГОЛ	19,882,823,110.00
19	ТАЛХ ЧИХЭР	19,450,357,000.00
20	ДАРХАН НЭХИЙ	17,687,664,000.00
21	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	17,356,741,667.50
22	АРД ДААТГАЛ ХК	17,198,500,000.00
23	ТАХЬ-КО	16,493,164,380.00
24	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	13,972,598,968.00
25	БИ ДИ СЕК	13,940,000,000.00
26	МОНГОЛ БАЗАЛТ ХК	13,934,999,000.00
27	АРИГ ГАЛ	12,525,552,000.00
28	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	12,199,128,647.80
29	МОНГОЛ СЕКЮРИТИЕС	12,000,000,000.00
30	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	11,913,510,400.00
Нийт		2,219,737,235,742.89
Нийтэд эзлэх хувь		90.5

Зах зээлийн үнэлгээ өндөр 30 компанийн үнэлгээ нийт зах зээлийн үнэлгээний 90.5 хувийг эзэлж байна.



4. ТОП-20 индекс

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21888.16 нэгж, доод үзүүлэлт 20744.94 нэгж, дундаж үзүүлэлт 21315.83 нэгж байна. ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 195.75 нэгжээр буюу 0.93 хувиар буурч, 20826.08 нэгж болсон байна.



Арилжааны алба